



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2016 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/249

Булган

Татвар төлөгчдийн өдрүүдийг
тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.е, “Төсвийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалт, Татварын ерөнхий газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/55 тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Татвар төлөгчдийн өдрүүд 2018” арга хэмжээг Булган аймагт 2018 оны 5 дугаар сарын 07-ны өдрөөс 11-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулахыг Татварын хэлтэс /Д.Батцогт/-т даалгасугай.

2. Татвар төлөгчдийн дунд зохион байгуулах шатрын тэмцээн, болзолт уралдааны шагналын зардлыг нэгдүгээр, татвар төлөгчдөд зориулсан сургалт, сурталчилгааны зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, уг арга хэмжээнд шаардагдах 4427000 /дөрвөн сая дөрвөн зуун хорин долоон мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-т зөвшөөрсүгэй.

3. Татвар төлөгчдийн өдрийг сумдад зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг тухайн сумын төсвөөс гаргахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Татвар төлөгчдийн өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлсэн тухай тайланг 5 дугаар сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнахыг Татварын хэлтэс /Д.Батцогт/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

Захирамж-2018 он

10/1

Аймгийн Засаг даргын 2018 оны 04
дүгээр сарын 26-ны өдрийн *Х* дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

**“ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ӨДРҮҮД 2018” АРГА ХЭМЖЭЭНИЙ
УРАЛДААН ТЭМЦЭЭНИЙ ЗАРДЛЫН ДҮН**

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт зардлын дүн
Болзолт уралдааны шагнал				
1	Гар зургийн уралдаан	4	30,25,20,10	85,000
	Талархал	100	1,500	150,000
2	Зохион бичлэгийн уралдаан	4	30,25,20,10	85,000
	Талархал	100	1,500	150,000
3	МСҮТ, ЕБС-н багш, оюутнуудын дунд Монгол үндэсний хэлбэртэй, татварын агуулгатай хүүхэд залуучуудын сэтгэхүй хөгжүүлэх тоглоомын уралдаан	4	100,80,50	230,000
4	Болзолт уралдаанд оролцсон хүүхэд бүрт урамшуулал талархалын хамт гарын бэлэг	250	3,000	750,000
5	Өргөмжлөл	12	2500	30,000
	Дүн			1,480,000
Татвар төлөгчдийн дунд зохион байгуулах тэмцээн				
6	Шатар /6-8/ эр, эм	6	40,35,30*2	210,000
	9-12 нас эр, эм	6	40,35,30*2	210,000
	13-15 нас эр, эм	6	40,35,30*2	210,000
	16-18 нас эр, эм	6	40,35,30*2	210,000
	Насанд хүрэгчид эр, эм	6	40,35,30*2	210,000
	Шүүгчийн цалин			90,000
7	Өргөмжлөл	30	2500	75,000
	Дүн			1,215,000
	Нийт дүн			2,695,000

Аймгийн Засаг даргын 2018 оны 04 сарын
 05 өдрийн дугаар захирамжийн
 Хавсралт № 02

“ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ӨДРҮҮД 2018” АРГА ХЭМЖЭЭНИЙ
 СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДЛЫН ДҮН

д/д	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт зардлын дүн
1	Телевизийн нэвтрүүлэг бэлтгэх /шилдэг сурталчилах/	1	300,000	300,000
2	Шилдэг татвар төлөгчдийг сурталчилсан хуанли гаргах	100	8000	800,000
3	Сурталчилгааны самбар /1,8*0,80/	2	45,000	90,000
4	Аннос /4*5/ сурталчилгааны самбар, бөгж, олс	1	150,000	150,000
5	Татвар төлөгчдөд зориулсан тараах материал хэвлэх өнгийн цаас /6*50*16=4800ш/+/6*100=600ш/=4900	49	8000	392,000
	Нийт дүн			1,732,000